# МОНГОЛ УЛСЫН
# ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН
# ЗӨВЛӨЛИЙН ЗӨВЛӨМЖ

2017 оны 01 сарын 10 өдөр Дугаар 03/03 Улаанбаатар хот

Нийслэлийн агаар, орчны бохирдлын тухай

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн өргөтгөсөн хуралдаанаар "Нийслэлийн агаар, орчны бохирдлын тухай" Монгол Улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбатын танилцуулга, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Батболдын нэмэлт мэдээллийг хэлэлцээд Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 2, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.4.3.4-ийн заалтыг тус тус үндэслэн ЗӨВЛӨМЖ болгох нь:

Нэг. Монгол Улсын Их Хуралд:

1.1. Агаар, ус, хөрсний бохирдол гамшгийн түвшинд хүрсэн гэж үзэж онцгой байдлын горимоор ажиллах, гамшгийн бүс тогтоож хориглох зүйлсийг гаргах, нүүлгэн шилжүүлэх, нөхөн сэргээх, дахин төлөвлөх үйл ажиллагааны эрх зүйн орчинг сайжруулж холбогдох хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах;

1.2. Төрийн захиргааны төв байгууллагууд, төмөр зам, их дээд сургуулиуд, тэдгээрийг дагасан дэд бүтцийн байгууламжуудыг нүүлгэн шилжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх;

1.3. Агаар, орчны бохирдлыг бууруулах, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар төрийн бүх шатны байгууллага, албан тушаалтан, аж ахуйн нэгж, байгууллага, иргэний хүлээх үүрэг, хариуцлагын тогтолцоог бий болгох эрх зүйн орчинг бүрдүүлэх;

1.4. Орчны бохирдлыг бууруулахад иргэд, байгууллагын оролцоо, хамтын ажиллагаа, олон нийтийн хяналтыг хангах эрх зүйн орчинг бүрдүүлэх;

1.5. Агаар, орчны бохирдлын асуудлыг Улсын Их Хурлын чуулган бүрийн хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд тусган хэлэлцэж байх, шаардлагатай тохиолдолд ээлжит бус чуулган хуралдуулах;

1.6. 2017 оны эхний улиралд Улсын Их Хурлын ээлжит бус чуулганыг хуралдуулан энэхүү зөвлөмжийн 1.1-1.4-т заасан асуудлыг хэлэлцэж, Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийг батлах.